

Аудитын ажлын чанарт нөлөөлөх хувь хүний хүчин зүйлийг тодорхойлох нь

Determining Individual Factors Influencing Audit Quality

Б. Баасансүрэн¹, Д. Авирмэд², Э. Цэцэгдэлгэр³

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь аудитын ажлын чанарт нөлөөлөх хувь хүний хүчин зүйлсийг тодорхойлон тэдгээрийн нөлөөллийг эмпирик түвшинд үнэлэхэд оршино. Монгол Улсад ажиллаж буй 80 аудиторын өгөгдөлд тулгуурлан PLS-SEM аргаар хийсэн шинжилгээний үр дүнгээс аудиторын нээлттэй байдал болон хариуцлагатай хянуур нямбай байдал нь аудитын чанарт статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлж байгааг тогтоов. Харин нийтэч байдал, экстраверт байдал болон сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал нь ач холбогдолгүй гарсан байна. Судалгааны үр дүн нь аудитын чанарыг зөвхөн мэргэжлийн мэдлэг, ур чадвараар бус аудиторын зан төлөвийн онцлогтой уялдуулан авч үзэх шаардлагатайг харуулж, аудитын байгууллагын хүний нөөцийн бодлого, сургалтын үйл ажиллагаанд практик ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: аудитын чанар, хувь хүний хүчин зүйл, зан төлөв, PLS-SEM, аудитор

Abstract

The purpose of this study is to identify individual factors influencing audit quality and to empirically evaluate their impact. Using data collected from 80 auditors in Mongolia, the relationships between auditors' behavioral traits and audit quality were analyzed using the PLS-SEM method. The results show that openness and conscientiousness have statistically significant positive effects on audit quality, while agreeableness, extraversion, and emotional stability do not show significant influence. The findings suggest that audit quality should be evaluated not only in terms of professional knowledge and skills but also in relation to individual behavioral characteristics, providing practical implications for human resource management and training in audit firms.

Keywords: audit quality, individual factors, personality traits, PLS-SEM, auditors

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн магистрант
E-mail: 20M1NUM0038@stud.num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: avirmedd@num.edu.mn

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: tsetsegdelger@num.edu.mn

Удиртгал

Орчин үеийн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагуудын шийдвэр гаргалт нь санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлаас ихээхэн хамаарах болсон. Иймд санхүүгийн тайлангийн бодитой байдлыг баталгаажуулах аудитын үйл ажиллагааны үүрэг, ач холбогдол улам нэмэгдэж, аудитын ажлын чанар нь хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч болон бусад мэдээлэл хэрэглэгчдийн шийдвэрт шууд нөлөөлөх чухал хүчин зүйл болж байна.

Аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн талаар олон улсын судалгаанд аудитын байгууллагын хэмжээ, нэр хүнд, хууль эрх зүйн орчин, мэргэжлийн стандарт, аудиторын туршлага зэрэг олон талт хүчин зүйлсийг авч үзсэн байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд аудитын чанарыг зөвхөн бүтэц, системийн хүчин зүйлсээр хязгаарлах бус, аудиторын хувь хүний зан төлөв, сэтгэл зүйн онцлог, мэргэжлийн хандлагатай уялдуулан судлах хандлага нэмэгдэж байна.

Монгол Улсад аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох чиглэлээр тодорхой судалгаанууд хийгдсэн хэдий ч эдгээр нь ихэвчлэн байгууллагын түвшний болон ерөнхий хүчин зүйлсийг авч үзсэн байдаг бөгөөд аудиторын хувь хүний шинж, зан төлөвийн нөлөөллийг тоон шинжилгээ, шалтгаант хамаарлын түвшинд нарийвчлан судалсан ажил харьцангуй хязгаарлагдмал байна.

Иймээс аудитын чанарт хүний хүчин зүйлийн гүйцэтгэх үүргийг илүү гүнзгий судлах шаардлага зүй ёсоор үүсч байна. Ялангуяа аудиторын нээлттэй байдал, хариуцлагатай байдал, сэтгэл хөдлөлийн

тогтвортой байдал, нийтэч байдал зэрэг зан төлөвийн үзүүлэлтүүд аудитын ажлын чанарт хэрхэн нөлөөлж байгааг эмпирик түвшинд тодорхойлох нь онолын болон практикийн хувьд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны зорилго нь аудитын ажлын чанарт нөлөөлөх хувь хүний хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг статистик шинжилгээний аргаар үнэлэхэд оршино. Судалгааны үр дүн нь аудитын байгууллагын хүний нөөцийн бодлого, сургалт, чанарын хяналтын тогтолцоог сайжруулахад бодитой хувь нэмэр оруулах боломжтой.

Судлагдсан байдал

Аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа нь олон улсын түвшинд өргөн хүрээнд хөгжсөн бөгөөд эхэн үедээ голчлон аудитын байгууллагын онцлог, зах зээлийн орчин, мэргэжлийн стандарт зэрэг институцийн хүчин зүйлсэд анхаарч ирсэн байна. Тухайлбал, DeAngelo (1981) аудитын байгууллагын хэмжээ нь аудитын чанарт чухал нөлөөтэйг онол-эмпирикийн үүднээс тайлбарлаж, томоохон аудитын байгууллага илүү чанартай аудит гүйцэтгэх хандлагатайг тодорхойлсон. Үүний дараагаар Francis (2004) аудитын чанарыг зөвхөн аудиторын хувь хүний түвшинд бус, аудитын баг, байгууллага, мэргэжлийн стандарт, хууль эрх зүйн орчин болон зах зээлийн хяналтын тогтолцоо зэрэг олон түвшний хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойлогдох цогц ойлголт гэж үзсэн нь судалгааны хүрээг өргөжүүлсэн байна.

Цаашлаад судлаачид аудитын чанарт байгууллагын нэр хүнд, дотоод бодлого, менежментийн орчин зэрэг институцийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөг судалж ирсэн. Жишээлбэл, Aronmwan нарын

судалгаанд аудитын байгууллагын нэр хүнд нь аудитын үйлчилгээний чанарт хамгийн чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйлсийн нэг бөгөөд хэрэглэгчдийн хувьд нэр хүндтэй байгууллагыг сонгох нь илүү найдвартай аудитын баталгаа авах нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзсэн. Мөн Sulaiman нар (2018) аудитын чанарыг сайжруулахад байгууллагын дотоод зохион байгуулалт, бодлого, менежмент зэрэг дотоод орчны хүчин зүйлс чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэсэн байна.

Сүүлийн үеийн судалгаанд аудитын чанарыг тодорхойлох хандлага илүү нарийсч, хүний зан төлөв болон хувь хүний хүчин зүйлсийн нөлөөг судлах чиглэл нэмэгдэх болсон. Sugondo нар (2025) аудиторын зан төлөв, шийдвэр гаргалтын онцлог нь аудитын ажлын чанарт хэрхэн нөлөөлж байгааг судалсан бол Zahmatkesh & Rezazadeh (2017) аудиторын хувь хүний онцлог шинжүүд аудитын чанарт үзүүлэх нөлөөллийг тооцоолон үнэлсэн байна. Эдгээр судалгааны үр дүн нь аудитын чанар нь зөвхөн байгууллагын эсвэл орчны хүчин зүйлсээр бус, аудиторын хувь хүний шинж чанар, зан төлөвтэй салшгүй холбоотой болохыг харуулж байна.

Монгол Улсын хувьд аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан ажлууд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа бөгөөд энэ чиглэлийн судалгаа аажмаар гүнзгийрч, өргөжин хөгжиж байна. Тухайлбал, Дамдиндорж (2019) нь Монгол Улсад аудитын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлохдоо аудитын байгууллагын онцлог, аудиторын чадвар, хууль эрх зүйн орчин зэрэг гол хүчин зүйлсийг харьцуулан авч үзэж, аудитын чанарыг тодорхойлох суурь ойлголтуудыг системтэйгээр нэгтгэн тодорхойлсон байдаг. Уг судалгаа нь

аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг ангилан авч үзсэнээрээ онолын суурь ач холбогдолтой боловч хувь хүний зан төлөвийн нөлөөллийг нарийвчлан задлан шинжлээгүй байна.

Түүнчлэн Лагнай нар (2024) аудитын үйлчилгээний чанарыг илүү өргөн хүрээнд авч үзэж, аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг зөвхөн аудиторын түвшинд бус байгууллага, орчин, бодлого, стандартын хослол бүхий цогц системийн хүрээнд тайлбарласан байна. Энэхүү судалгаанд аудитын чанар нь олон талт хүчин зүйлсийн огтлолцлоор бүрддэг болохыг онцлон, онолын болон практикийн түвшинд шинжилсэн нь аудитын чанарын талаарх ойлголтыг өргөжүүлсэн ч хүний зан төлөвийн хүчин зүйлийг тоон аргаар хэмжихэд анхаарал бага хандуулсан байна.


Мөн Баялаг & Алтан-Эрдэнэ (2025) аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохын зэрэгцээ аудитын салбарт тулгамдаж буй асуудлуудыг авч үзэж, аудитын чанарыг сайжруулах боломжит арга зам, чиглэлүүдийг санал болгосон байдаг. Энэхүү судалгааны онцлог нь практик хэрэгжилтэд чиглэсэн шийдэл, зөвлөмжийг дэвшүүлсэнд орших бөгөөд аудитын чанарыг сайжруулахад бодлогын болон байгууллагын түвшний арга хэмжээнүүдийг онцолсон байна. Гэвч уг судалгаанд мөн адил хувь хүний зан төлөвийн хүчин зүйлийн нөлөөллийг математик загварчлал болон эмпирик байдлаар нарийвчлан шинжилсэн нь хязгаарлагдмал байна.

Дээрх судалгаануудыг нэгтгэн авч үзвэл Монгол Улсад аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, ангилах, сайжруулах арга замыг санал болгох

чиглэлд тодорхой дэвшил гарсан хэдий ч эдгээр судалгааны ихэнх нь байгууллагын болон орчны түвшний хүчин зүйлсэд төвлөрсөн нь ажиглагдаж байна. Харин аудиторын хувь хүний зан төлөв, сэтгэл зүйн шинж болон тэдгээрийн аудитын чанарт үзүүлэх нөлөөллийг тоон шинжилгээ, шалтгаант хамаарлын загвар ашиглан эмпирик түвшинд баталгаажуулсан судалгаа хязгаарлагдмал хэвээр байна.

Иймээс аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаанд хүний зан төлөвийн хүчин зүйлсийг нарийвчлан авч үзэж, тэдгээрийн нөлөөллийг статистик загварчлалын аргаар үнэлэх шаардлага тулгамдаж байгаа бөгөөд энэхүү судалгаа нь дээрх судалгааны зайг нөхөх зорилготой юм.

Зураг 1. Асуулгын үр дүн



Судалгааны үр дүн

Судалгаанд нийт 80 аудитор оролцсон бөгөөд оролцогчдын 70.6 хувь нь эмэгтэй, 70 орчим хувь нь 25-45 насны ангилалд хамаарч байна. Мөн 78.4 хувь нь нягтлан бодогч мэргэжилтэй бөгөөд 50 орчим хувь нь ахлах аудиторын албан тушаал эрхэлж байна. Зан төлөвийн өөрөө үнэлгээний үр дүнгээс харахад оролцогчдын 51.4 хувь нь хянуур нямбай, 20.2 хувь нь нээлттэй, 16.5 хувь нь сэтгэл хөдлөлийн хувьд тогтвортой зан төлөвтэй гэж хариулсан нь аудитын үйл ажиллагаанд хариуцлагатай, зохион байгуулалттай зан төлөв давамгайлж байгааг илтгэнэ (Зураг 1).


Хувьсагчдын хоорондын хамаарлыг загварчлан харуулах зорилгоор PLS-SEM аргачлалын дагуу бүтцийн зураглалыг боловсруулсан бөгөөд уг загварт зан төлөвийн хүчин зүйлсийг бие даасан хувьсагч, аудитын чанарыг хамааралтай

хувьсагчаар тодорхойлсон. Уг загвар нь судалгаанд ашигласан хувьсагчдын хоорондын уялдаа холбоо, нөлөөллийн чиглэлийг харуулж байна (Зураг 2).

Судалгаанд ашигласан хэмжилтийн загварын найдвартай болон хүчин төгөлдөр байдлыг шалгах зорилгоор үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд Cronbach's alpha, Composite reliability, Average Variance Extracted (AVE), Heterotrait-Monotrait Ratio (HTMT) зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан (Хүснэгт 1).

Шинжилгээний үр дүнгээс харахад бүх хувьсагчдын найдвартай байдлын үзүүлэлтүүд шаардлагыг хангаж, Cronbach's alpha болон Composite reliability утгууд 0.70-аас дээш, AVE утгууд 0.50-аас дээш, HTMT үзүүлэлтүүд 0.85-аас бага гарсан нь хэмжилтийн загвар нь статистикийн хувьд найдвартай, хүчин

Зураг 2. Хувьсагчдын хамаарлын зураглал



Хүснэгт 1. PLS-SEM шинжилгээний коэффициентийн онолын утга

Коэффициентийн нэр	Тоо	Утга
Cronbach's alpha(CA)	≥0.7	Найдвартай
Composite reliability(CR)	≥0.7	Найдвартай
Heterotrait-Monotrait Ratio (HTMT)	≤0.85	Ялгаатай/бие даасан
Average variance extracted (AVE)	≥0.5	Хүчин төгөлдөр

Хүснэгт 2. Найдвартай байдлын үнэлгээ

	Cronbach's alpha	Composite reliability	HTMT	Average variance extracted (AVE)
Аудитын чанар	0.929	0.937		0.507
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	0.850	0.916	0.293	0.602
Нээлттэй байдал	0.836	0.853	0.7210	0.607
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	0.864	0.866	0.332	0.649
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.784	0.808	0.694	0.540
Экстраверт	0.849	0.849	0.529	0.623

Хүснэгт 3. Тодорхойлох статистик

	Mean	Median	Min	Max	Observations	Standard deviation	t-stat.	p value
Аудитын чанар	0.000	0.192	-3.554	1.110	80	1.000	0.257	0.001
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	0.000	0.187	-3.158	1.008	80	1.000	0.587	0.000
Нээлттэй байдал	0.000	0.178	-3.241	1.122	80	1.000	0.287	0.000
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	0.000	-0.116	-2.565	1.248	80	1.000	0.257	0.001
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.000	0.350	-3.513	1.004	80	1.000	0.516	0.000
Экстраверт	0.000	-0.026	-2.984	1.247	80	1.000	0.156	0.019

Хүснэгт 4. Корреляцийн матриц

	Аудитын чанар	Нийтэч эелдэг зөөлөн байдал	Нээлттэй байдал	Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	Хариуцлагатай хянуур нямбай байдал
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	0.299 ***				
Нээлттэй байдал	0.666 ***	0.473			
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	0.310 ***	0.649	0.484		
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.616 ***	0.428	0.620	0.354	
Экстраверт	0.492 ***	0.605	0.644	0.661	0.522

төгөлдөр болохыг баталж байна (Хүснэгт 2).

Тодорхойлох статистикийн шинжилгээгээр хувьсагчдын тархалтын ерөнхий шинжийг

тодорхойлоход стандарт хазайлтын утгууд тогтвортой (ойролцоогоор 1) байгаа нь өгөгдөл жигд тархалттай байгааг илтгэж байна. Мөн бүх хувьсагчдын ажиглалтын

Хүснэгт 5. Нэгдсэн үр дүн

Аудитын чанар	Path coefficients	Sample mean	Standard deviation	t stat.	p-value
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	-0.103	-0.086	0.135	0.769	0.442
Нээлттэй байдал	0.454	0.456	0.109	4.151	0.000
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	-0.034	-0.030	0.141	0.238	0.812
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.333	0.339	0.108	3.090	0.002
Экстраверт	0.111	0.106	0.125	0.883	0.378

Хүснэгт 6. Стандарт ба нийцэл хэмжүүрийн үр дүн

Аудитын чанар	Path coefficients	Sample mean	Standard deviation	t stat.	p-value
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	-0.089	-0.085	0.146	0.613	0.540
Нээлттэй байдал	0.215	0.209	0.137	1.573	0.116
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	-0.042	-0.003	0.158	0.267	0.790
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.407	0.414	0.132	3.082	0.002
Экстраверт	0.076	0.065	0.131	0.579	0.562

Хүснэгт 7. Нотлох зүйлийн чанар хэмжүүрийн үр дүн

Аудитын чанар	Path coefficients	Sample mean	Standard deviation	t stat.	p-value
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	-0.036	-0.021	0.169	0.214	0.83
Нээлттэй байдал	0.433	0.428	0.134	3.231	0.001
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	-0.154	-0.115	0.174	0.886	0.376
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.184	0.193	0.115	1.607	0.108
Экстраверт	0.181	0.166	0.157	1.154	0.249

тоо ижил байгаа нь статистик шинжилгээ хийхэд тохиромжтой өгөгдлийн бүтэц бүрдсэнийг харуулж байна (Хүснэгт 3).

Корреляцийн шинжилгээний үр дүнгээс аудитын чанар нь нээлттэй байдал ($r=0.666$), хариуцлагатай хянуур нямбай байдал ($r=0.616$), экстраверт байдал ($r=0.492$), сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал ($r=0.310$), нийтэч байдал ($r=0.299$) зэрэг хувьсагчидтай статистикийн ач холбогдол бүхий эерэг хамааралтай байна (Хүснэгт 4).

PLS-SEM бүтцийн загварын шинжилгээний үр дүнгээс үзэхэд нээлттэй байдал болон хариуцлагатай хянуур нямбай байдал

нь аудитын чанарт статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлж байна. Харин бусад зан төлөвүүдийн хувьд статистикийн ач холбогдол илрээгүй бөгөөд энэ нь аудитын чанарт бүх зан төлөв ижил түвшинд нөлөөлөхгүй, харин тодорхой хүчин зүйлс давамгайл үүрэгтэйг илтгэнэ (Хүснэгт 5).

Стандарт ба нийцэл хэмжүүрийн түвшинд хийсэн шинжилгээнээс харахад зөвхөн хариуцлагатай хянуур нямбай байдал нь статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлсэн байна. Энэ нь хувь хүн хэдий чинээ хариуцлагатай, зохион байгуулалттай байна, төдий чинээ

Хүснэгт 8. Аудиторын ур чадвар ба туршлага хэмжүүрийн үр дүн

Аудитын чанар	Path coefficients	Sample mean	Standard deviation	t stat.	p-value
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	0.076	0.079	0.141	0.536	0.592
Нээлттэй байдал	0.451	0.425	0.124	3.629	0.000
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	-0.040	-0.046	0.173	0.229	0.819
Хариуцлагатай хянуур нямбай байдал	-0.134	-0.113	0.120	1.116	0.264
Экстраверт	0.320	0.351	0.158	2.017	0.044

Хүснэгт 9. Төлөвлөлт ба гүйцэтгэл хэмжүүрийн үр дүн

Аудитын чанар	Path coefficients	Sample mean	Standard deviation	t stat.	p-value
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	-0.051	-0.039	0.120	0.426	0.670
Нээлттэй байдал	0.535	0.538	0.113	4.738	0.000
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	0.054	0.050	0.131	0.411	0.681
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.270	0.272	0.099	2.727	0.006
Экстраверт	-0.048	-0.044	0.137	0.348	0.727

Хүснэгт 10. Тайлангийн нээлттэй ил тод байдал хэмжүүрийн үр дүн

Аудитын чанар	Path coefficients	Sample mean	Standard deviation	t stat.	p-value
Нийтэч/Эелдэг зөөлөн байдал	-0.107	-0.137	0.183	0.582	0.560
Нээлттэй байдал	0.224	0.235	0.134	1.670	0.095
Сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал	-0.003	0.062	0.178	0.018	0.986
Хариуцлагатай хянуур нямбай байдал	0.529	0.539	0.112	4.729	0.000
Экстраверт	0.012	-0.020	0.151	0.081	0.936

стандарт, дүрэм журмыг мөрдөх хандлага өндөр байдгийг илтгэж байна (Хүснэгт 6).

Нотлох зүйлийн чанарын хэмжүүр дээр хийсэн шинжилгээгээр нээлттэй байдал нь статистикийн ач холбогдол бүхий хүчтэй нөлөө үзүүлж байна. Энэ нь шинэ мэдээлэл хүлээн авах, шинийг эрэлхийлэх хандлага нотлох баримтыг илүү чанартай бүрдүүлэхэд чухал үүрэгтэйг харуулж байна (Хүснэгт 7).

Аудиторын ур чадвар ба туршлагад нээлттэй байдал болон экстраверт зан төлөв статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлж байгаа нь ажиглагдсан. Энэ нь шинэ мэдлэг эзэмших хандлага

болон харилцааны чадвар нь мэргэжлийн чадамжийг нэмэгдүүлэхэд чухал болохыг илтгэнэ (Хүснэгт 8).

Төлөвлөлт ба гүйцэтгэлийн хэмжүүрт нээлттэй байдал болон хариуцлагатай байдал хамгийн хүчтэй нөлөө үзүүлсэн байна. Энэ нь шинэ санааг хүлээн авах чадвар болон ажлын сахилга бат нь аудитын үйл явцын чанарт шууд нөлөөлдөг болохыг харуулж байна (Хүснэгт 9).

Тайлангийн нээлттэй, ил тод байдлын хэмжүүрт зөвхөн хариуцлагатай хянуур нямбай байдал статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлж байна. Энэ нь хариуцлагатай зан төлөвтэй аудитор

тайлангийн ил тод байдлыг өндөр түвшинд хангах хандлагатайг илтгэнэ (Хүснэгт 10).

Дээрх үр дүнг нэгтгэн үзвэл аудитын чанарт нээлттэй байдал болон хариуцлагатай хянуур нямбай байдал нь хамгийн чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд эдгээр зан төлөвүүд нь аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, нотлох баримтын чанар болон тайлангийн ил тод байдал зэрэг олон хэмжүүрт давтагдан илэрч байна. Энэ нь аудитын чанарыг сайжруулахад хүний зан төлөвийн хүчин зүйлсийг нарийвчлан авч үзэх шаардлагатайг баталж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар аудитын ажлын чанарт нөлөөлөх хувь хүний хүчин зүйлсийг тодорхойлох зорилт тавьж, аудиторын зан төлөвийн үзүүлэлтүүдийн нөлөөллийг PLS-SEM аргаар эмпирик түвшинд шинжилж дүгнэлт гаргалаа.

Судалгааны үр дүнгээс харахад аудитын чанар нь бүх зан төлөвийн хүчин зүйлсээс ижил түвшинд хамаарахгүй бөгөөд тодорхой зан төлөвүүд илүү хүчтэй нөлөөлдөг болох нь тогтоогдов. Тодруулбал, нээлттэй байдал болон хариуцлагатай хянуур нямбай байдал нь аудитын чанарт статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлж байгаа нь батлагдсан бол нийтэч байдал, экстраверт зан төлөв, сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал зэрэг хүчин зүйлсийн нөлөө статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан байна.

Нээлттэй байдал нь нотлох зүйлийн чанар, аудиторын ур чадвар, төлөвлөлт ба гүйцэтгэлийн үйл явцад эерэг нөлөө үзүүлж байгаагаараа аудитын ажлын чанарыг сайжруулах чухал хүчин зүйл болохыг харуулсан. Харин хариуцлагатай хянуур нямбай байдал нь стандарт ба нийцэл, төлөвлөлт, тайлангийн ил тод байдал зэрэг аудитын үндсэн процессуудад нөлөөлж, аудитын чанарын суурь шинжийг тодорхойлж байна.

Эдгээр үр дүн нь аудитын чанарыг зөвхөн мэргэжлийн мэдлэг, туршлагаар бус, аудиторын хувь хүний зан төлөвийн онцлогтой уялдуулан авч үзэх шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл, аудитын байгууллагууд хүний нөөцийн бодлого, сургалт, хөгжлийн хөтөлбөртөө аудиторын зан төлөвийн онцлогийг харгалзан үзэх нь аудитын чанарыг сайжруулахад бодитой нөлөө үзүүлэх боломжтой.

Судалгааны үр дүн нь Монгол Улсад аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг судлах чиглэлд хувь хүний зан төлөвийн нөлөөллийг статистик аргаар тодорхойлсон цөөн судалгааны нэг болж, онолын болон практикийн ач холбогдолтой дүгнэлтүүдийг гаргаснаараа онцлог юм. Гэсэн хэдий ч судалгаа нь түүврийн хэмжээ хязгаарлагдмал бөгөөд зөвхөн тодорхой бүлгийн аудиторуудад үндэслэсэн тул цаашдын судалгаанд илүү өргөн хүрээний өгөгдөл ашиглах, бусад хувьсагчдыг хамруулах шаардлагатай байна.

Ашигласан материал

- DeAngelo, L. E. (1981). Auditor size and audit quality. *Journal of Accounting and Economics*, 3(3), 183-199. [https://doi.org/10.1016/0165-4101\(81\)90002-1](https://doi.org/10.1016/0165-4101(81)90002-1)
- Francis, J. R. (2004). What do we know about audit quality?. *The British Accounting Review*, 36(4), 345-368. <https://doi.org/10.1016/j.bar.2004.09.003>
- Knechel, W. R., Krishnan, G. V., Pevzner, M., Bhaskar, L. S., & Velury, U. (2013). Audit quality: Insights from the academic literature. *Journal of Practice & Theory*, 32(1), 385-421.
- Ladewi, Y., Welly, W., Astrina, F., Nurhayati, N., & Lestari, R. (2022). Factors affecting the quality of audit. *Jurnal Sosial dan Pembangunan*, 38(2), 414- 422. <https://doi.org/10.29313/mimbar.v0i0.10472>
- Sarwar, S., Hussain, K., Shakir, M. M. N., & Ali, M. A. (2024). Impact of external auditors' ethical behavior on audit quality: A client perspective. *Journal of Accounting and Finance in Emerging Economies*, 10(3), 401-414. <https://doi.org/10.26710/jafee.v10i3.3109>
- Serdouk, F., Khalida, A., Ben Amor M. B., Abdelatif, T. (2024). A comprehensive analytical framework of audit quality. *Journal of Informatics Education and Research*, 4(3), 3654-3671.
- Sugondo, L. Y., Ismail, T., Yulianto, A. S., Ibrani, E. Y. (2025). Effects on auditors' behavioral factors on audit quality. *Journal of Economics Finance and Management Studies*, 8(9), 6537-6561. <https://doi.org/10.47191/jefms/v8-i9-62>
- Watts, R. L., & Zimmerman, J. L. (1983). Agency problems, auditing, and the theory of the firm: Some evidence. *Journal of Law & Economics*, 26(3), 613-633. <https://doi.org/10.1086/467051>
- Zahmatkesh, S., & Rezazadeh, J. (2017). The effect of auditor features on audit quality. *Tékhne*, 15(2), 79-87. <https://doi.org/10.1016/j.tekhne.2017.09.003>
- Баялаг, Г., & Алтан-Эрдэнэ, Б. (2025). Аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлс ба тулгамдаж буй асуудлууд. *Бизнес ба Инноваци*, 11(2), 81-89. <https://doi.org/10.22353/jbai.2025110207>
- Дамдиндорж, Н. (2019). Аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлийн харьцуулсан судалгаа. *Бизнес & Инноваци*, 5(2), 147-155. <https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/article/view/2362>
- Лагнай, Т., Нямаа, Д., Авирмэд, Д., & Хишигбаяр, Л. (2024). Санхүүгийн тайлангийн аудитын чанарын асуудал. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 8(1), 19-25. <https://journal.num.edu.mn/accounting/article/view/9718>